

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Үнэт цаас гаргагчийн нэр:
Үнэт цаас гаргагчийн хаяг:

“Хай Би Ойл” Хувьцаат Компани

Улаанбаатар хот, Сонгинохайрхан
дүүрэг, 20-р хороо, Сонсголон
Холбоо барих утас: 70112205, 99098989

Улсын бүртгэлийн тухай товч мэдээлэл

Компанийн нэр:	“Хай Би Ойл” ХК
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2007.12.27
Улсын бүртгэлийн дугаар:	9010001063
Регистрийн дугаар:	2615134
Үйл ажиллагааны чиглэл:	- Техникийн тосны үйлдвэрлэл - Гадаад, дотоод худалдаа
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	327 хувьцаа эзэмшигчидтэй. /2016 оны 3 сарын 18-ны өдрийн тархалтын судалгаа/

Компанийн танилцуулга

“Хай Би Ойл” ХК нь Монголд анх удаа техникийн ажилласан тосыг цэвэршүүлэн эдийн засгийн эргэлтэнд оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэр байгуулахаар Хонг Конгийн DUNWELL GROUP.,LTD компанийн 200 тонн ажилласан тос боловсруулах хүчин чадалтай VSEP технологийн V-MAT I-36 системийн ажилласан тос цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг оруулан ирж, Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах өөрийн үйлдвэрийн талбайд 2008 оны 9 сард бүрэн угсарч дууссан. Улмаар 10 сараас үйлдвэрийг бүрэн ажиллагаанд оруулсан боловч 1 сарын хугацаанд ажиллаад эрчим хүчний таслалтаас үүдэн үйлдвэрийн гол дамжлага болох мембаран шүүлтүүр VMAT I-36 нь бохирдож үйлдвэр явуулахад хүндрэлтэй болж, уг шүүлтүүрийг сольсноор буюу 2010 оны 5 сараас бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлснээс хойш хэвийн ажиллаж байна.

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

2016 онд хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрлэлд онц ноцтой буюу гэнэтийн гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажилласан. Тайлант хугацаанд **753’362** литр хаягдал тос буюу үйлдвэрийн түүхий эдийг цуглуулахад **204’670’900** төгрөгийн зарлага гарсан ба үүний 33,8 хувийг аж ахуйн нэгж, 66,2 хувийг хувь хүнээс худалдан авсан. Үүнээс харахад нэг литр ажилласан маслыг дунджаар **271,67** төгрөгөөр худалдаж авсан байна.

№	Түүхий эд худалдан авсан газар	Түүхий эдийн хэмжээ /литр/	Түүхий эдийн үнэ /төгрөг/
1	Аж ахуйн нэгж (8 ААН)	254'751	65'981'280
2	Хувь хүн (18 Х/Х)	498'611	138'689'620
Нийт дүн		753'362	204'670'900

2016/04/01-ээс 2016/12/31-ний өдрийг хүртэл тос боловсруулах үйлдвэр нь ажилласан ба тайланд хугацаанд нийт **662'281** литр мазут М100 үйлдвэрлэж үүнээс нийлбэр дүнгээр **590'687** литрийг **493'768'200** төгрөгөөр борлуулалт хийсэн байна. Хүснэгтээр харуулбал:

№	Худалдан авсан байгууллагын нэр	Хэмжээ /литр/	НӨАТ ороогүй үнэ		НӨАТ орсон үнэ /төгрөг/	
			Нэгж үнэ	Нийт үнэ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	“УВТ инвест” ХХК	198'244			810	160'578'000
2	“МБИ” ХХК	86'400			850	73'440'000
3	“Наранбулаг хан” ХХК	151'355			850	128'651'750
4	“Дэвжих-Эрдэнэ” ХХК	91'990			850	78'191'500
5	“Тэгшт плант” ХХК	24'498			850	20'823'300
6	“Эко асфальт” ХХК	24'000			850	20'400'000
7	“Арж капитал” ХХК	2'000			850	1'700'000
8	Иргэн Ц.Жаргалсайхан	5'000	773	3'863'650		
9	“Ялгуусан” ХХК	7'200			850	6'120'000
Бүгд дүн		590'687	3'863'650		489'904'550	

2016 оны нийт борлуулалтыг өмнөх оны хугацаатай харьцуулвал 17,8 хувиар буурсан ба энэ нь 2016 онд Их хурал, Засгийн газар солигдож зам барилгын хөрөнгө оруулалтын мөнгийг гацаасантай холбоотой гэж үзэж байгаа.

2016.12.30-ны өдрийн байдлаар түүхий эд болон боловсруулсан бүтээгдэхүүний нөөц дараах байдалтай байна.

Түүхий эдийн нөөц 51'800 литр

Боловсруулсан тос /Мазут/ 76'620 литр

Хөрөнгө оруулалт, засаж сайжруулсан зүйлс:

2016 онд тосны үйлдвэрт томоохон засвар үйлчилгээ хийгдээгүй болно. Харин хөдөлмөрийн аюулгүй байдалыг хангах үүднээс зурагт хуудас, самбар, наалт, галын хорыг шинэчилсэн. Мөн ажилчдын аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж улирлын нормын дулаан хувцас, гутал, хэрэглэлийг авсан.

Гэрээ хэлцэлүүд болон томоохон худалдан авагчид:

2016 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 3 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 4 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 6 ширхэг гэрээнүүдийг тус бүр байгуулсан байна.

№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Эхлэх	Дуусах	Гэрээний үнэ
Түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой					
1	ҮЦГТТХТ	Хадгаламжийн гэрээ	2016/03/09		
2	ХХБанк	Онлайн үйлчилгээний гэрээ	2016/05/09		
3	“Адореси” ХХК	Гаражийн түрээс	2016/04/01		
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ					
4	“МХБ” ТӨХК	Бүртгэлийн гэрээ	2016/04/09		
5	Иргэн Э.Эрдэнэбуян	Түр ажилтан	2016/06/27	2017/08/16	
6	СХД, 20 хороо	Хог, хаягдлын тээвэрлэлтийн гэрээ	2016/06/06	2017/06/06	
7	СХД, 20 хороо, ТҮГ	Тохижилт, цэвэрлэгэжэний гэрээ	2016/06/14	2017/06/14	
Худалдах, худалдан авах гэрээ					
8	“Наранбулаг хан” ХХК	Мазут худалдах	2016/05/19	2017/05/19	212’500’000₮
9	“Эко асфальт” ХХК	Мазут худалдах	2016/05/19	2017/05/19	212’500’000₮
10	“Тэгш плант” ХХК	Мазут худалдах	2016/04/26	2017/04/26	129’000’000₮
11	“Дэвжих эрдэнэ” ХХК	Мазут худалдах	2016/06/08	2017/06/08	85’000’000₮
12	“Арбос” ХХК	Хаягдал тос бэлтгэн нийлүүлэх	2016/04/21	2016/06/01	51’000’000₮
13	“Шунхлай трейдинг” ХХК	Хаягдал тос бэлтгэн нийлүүлэх	2016/05/19	2017/05/19	

Томоохон худалдан авагчид:

№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Гэрээний үнэ /төгрөг/	Тайлбар
1	“Наранбулаг хан” ХХК	Мазут худалдан авах тухай	212’500’000₮	1 литр тутмыг 850₮-өөр нийт 250’000 литр авах
2	“Эко асфальт” ХХК	Мазут худалдан авах тухай	212’500’000₮	1 литр тутмыг 850₮-өөр нийт 250’000 литр авах
3	“Тэгш плант” ХХК	Мазут худалдан авах тухай	127’500’000₮	1 литр тутмыг 850₮-өөр нийт 150’000 литр авах
4	“Дэвжих эрдэнэ” ХХК	Мазут худалдан авах тухай	85’000’000₮	1 литр тутмыг 850₮-өөр нийт 100’000 литр авах

Бүгд үнэ	637'500'000₮	
----------	--------------	--

2017 онд хийгдэх зүйлс болон борлуулалтын таамаглалын тухайд:

Нийслэлийн автозамын хөгжлийн газраас 2017 онд Нийслэлд авто замын 39 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр мэдээлсэн. Тиймээс манай байгууллагатай хамтарч ажилладаг томоохон авто зам барилгын компаниуд “Наранбулаг хан” ХХК, “МБИ” ХХК, “УВТ инвест” ХХК, “Дэвжих-Эрдэнэ” ХХК, “Эко асфальт” ХХК-дын захиалгын дагуу ойролцоогоор 635 тонноос багагүй мазут нийлүүлэхээр төлөвлөж байна. Одоо байгаа түүхий эдийн нөөц бага байгаа тул 2017 оны 4 сард багтааж нийт 300 тонн хүртэл түүхий эдийг нөөцөлж авах шаардлагатай байна. Үүний тулд бид авто засварын газрууд болон зарим уул уурхайн компани, хувь хүмүүстэй харилцан ашигтай байхаар хэлэлцэж, техникийн хаягдал тос бэлтгэн нийлүүлэх гэрээг хийж байна.

Мөн тосны үйлдвэрийн боловсруулах үйл ажиллагааг сайжруулж, бүтээгдэхүүн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор боловсруулж байгаа тосны өнгө болоод чанарыг сайжруулах нэмэлт бүтээгдэхүүний талаар ОХУ-ын нефтийн чиглэлийн эрдэм шинжилгээний мэргэжилтэн, компаниудтай холбогдон бүтээгдэхүүн идэвхжүүлэлтийн талаар ажил үйлчилгээ, мэдлэг туршлагыг солилцож байна.

2017 оны эхний хагас жилд дараах ажил үйлчилгээнүүдийг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Үйлдвэрийн хашаанд байгаа өдөр хүчдэлийн трансформаторт ажил эхлэхээс өмнө шаардлагатай байгаа засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийг солиулах.
2. Худгаас үйлдвэр хүртэлх хөрийн усны хоолойг шинэчлэх, худагийн гаралтын хоолой трубаг шинэчлэн сольж хийх.
3. Оффисын орны тохижилт хийж, зүлэгжүүлэх.
4. Бүтээгдэхүүн болон түүхий эдийн худалдах, худалдан гэрээнүүдийг шинэчлэх.
5. Байгаль орчны болон хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх.
6. Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийг гүйцээж авах.
7. Үйлдвэрийн хашааны гүйдэг хаалганы замуудыг сэлбэж засварлах.
8. Машин техникүүдийг үзлэг оношилгоонд оруулахад бэлдэх.
9. Боловсруулж байгаа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах нэмэлт бүтээгдэхүүний талаарх судалгааны ажлыг эцэслэн шийдвэрлэх.







Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компанийн 2013, 2014, 2015, 2016 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	2013 он	2014 он	2015 он	2016 он
Борлуулалт	115,5	722,7	614,0	454.0
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-	
Цэвэр борлуулалт	115,5	722,7	614,0	454.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	94,6	469,5	347,3	376.7
Нийт ашиг	20,9	253,2	266,7	77.3
Үйл ажиллагааны бусад орлого				
Үйл ажиллагааны зардалд	1017	404	441,3	419.8
Үйл ажиллагааны бус ашиг /алдагдал /	203,5	455,9	210,5	642.3
Үйл ажиллагааны бус зардал				
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал /	(792,6)	305,1	35,9	299.8
Орлогын татварын зардал	1,1	6,0	9,1	51.5
Цэвэр ашиг /алдагдал /	(793,7)	299,1	26,8	248.3

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөр, авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь өгч, албан татварыг төлж байгаа.

2016 оны байдлаар 596.7 мянган литр мазут борлуулж 454.0 сая төгрөгийн орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 376.7 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 419.8 сая төгрөг, хүүгийн орлого 89.0 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний ашиг 558.7 сая төгрөг, орлогын албан татвар 51.5 сая төгрөг зардалтай нийт 248.3 сая төгрөгний ашигтай ажилласан байна.

Компани нь 2016 онд НДШ -76.1 сая төгрөг, ААНОАТ-т 8.7 сая төгрөг, ХАОАТ-41.3 сая төгрөг, НӨАТ-т 37.2 сая төгрөг, газрын төлбөр 1,5 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварт-15.1 сая төгрөг, Суутгагчийн хувь хүнд олгосон суутгасан албан татварт-6.3 сая төгрөг, АТӨЯХАТ-0.5 сая төгрөг нийт 186.7 сая төгрөг төлсөн.

Компанийн 2013 он, 2014 он, 2015 оны, 2016 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

сая /төгрөгөөр /

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2013 он	2014 он	2015 он	2016 он
Эргэлтийн хөрөнгө	3097.8	3183.8	3261.7	3716.6
Эргэлтийн бус хөрөнгө	6389.8	6498.4	6458.0	6410.6
Нийт хөрөнгийн дүн	9487.6	9682.2	9719.7	10127.2
Богино хугацаат өр төлбөр	9160.9	9056.4	704.7	896.4
Урт хугацаат өр төлбөр				
Эзэмшигчийн өмчийн дүн	326.7	625.8	9015	9230.8
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	9487.6	9682.2	9719.7	10127.2

Хөрөнгө санхүүгийн талаар

Тайлант онд компанийн нийт хөрөнгө 10'127'210.6 мянган төгрөг байгаа бөгөөд урд оноос 407'542.7 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хөрөнгийг дотор нь задалбал: дансан дахь мөнгө 133'812.1 мянган төгрөг, нийт авлага 3'494'067 мянган төгрөг, бараа түүхий эд материал урьдчилж гарсан зардал 88'711.9 мянган төгрөг эргэлтийн бус хөрөнгө 6'410'619.3 мянган төгрөг байна.

Өр төлбөр эзэмшигчийн өмчийн талаар

Өр төлбөр эзэмшигчийн өмчийн дүн 10'127'210,6 мянган төгрөг байгаагийн 896'403,5 мянган төгрөг нь богино хугацаат өр төлбөр, татварын өглөг 84'252.6 мянган төгрөг байна. Эздийн өмчийн дүн 9'230'807.1 мянган төгрөг байгаа нь тайлант оны ашиг 215'823 мянган төгрөгөөр өссөн байна. Гэвч энэ нь ханшийн зөрүүнээс олсон бодит бус хэрэгжээгүй ханшийн ашиг юм.

Улс орон нутгийн төсөвт оруулсан татвар шимтгэлийн талаар.

Тус компани тайлант хугацаанд улс орон нутгийн төсөвт 186'705.8 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн байна. Нийт татвар шимтгэлийг задалж харуулбал: НӨАТ-т 37'204.8 мянган төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн татварт 15'071.6 мянган төгрөг, газрын төлбөрт 1'560,2 төгрөг, ХАОАТ-т 41'306.9 мянган төгрөг, бусад татварт 6'279.3 мянган төгрөг, Агаарын бохирдол, АТӨЯХАТ 515.6 мянган төгрөг, ААНОАТ-т 8'698.5 мянган төгрөг, ЭМНД-ын шимтгэлд нийт 76'069.1 мянган төгрөг байна. Тайлант онд төлсөн татвар НДШ хураамжийг урд онтой харьцуулахад 78 хувиар буюу 16'222 мянган төгрөгөөр өссөн байна.


HBOil (L) Berhad

“HBOil (L) berhad” нь анх “Ninox hydrocarbons (L) berhad” нэртэйгээр 2011 оны 10 сард байгуулагдаж, Малайз улсад бүртгэгдсэн. Компанийн дугаар: LL08546. “Ninox energy”Ltd –ийн охин компани байсан ба 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар худалдан авах зөвшөөрлийг олгосны дагуу 2013 оны 9 дүгээр сард “Хай Би Ойл” ХК нь худалдан авснаар “Хай Би Ойл” ХК-ийн 100% охин болсон.

HBOil (L) berhad компанийн суурь хөрөнгө нь КОЕС International Inc –ийн хувьцааны 20 хувь бөгөөд 80 хувийг нь Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ)-ын газрын тосны үндэсний компани болох Солонгосын газрын тосны хайгуулын компани /КОЕС/ эзэмшдэг.

КОЕС INTERNATIONAL, INC-ийн бүтэц

Схем 1. КОЕС International Inc-ийн хөрөнгө оруулалтын бүтэц



Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	Hermes Petroleum(L)Berhad	33.25%
2	Firebird Mongol Holdings A S.A.R.L	18.86%
3	Firebird Global Master Holdings-2 S.A.R.L	13.01%
4	Triton energy limtied	8%
5	“БиДиСЕК” ХК	6.98%

Ногдол ашгийн талаархи мэдээлэл:

Компани нь хувьцаа эзэмшигчдэд 2016 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл

Компани их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Лхагвадорж, Ө.Хүдрээ, Б.Пүрэвбаатар, Кэйт Беннетт, Майк Рего, Д.Даянбилгүүн хараат бус гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн, Сий Кок Хенг, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Лхагвадорж, Гүйцэтгэх захирлаар Ө.Хүдрээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар дйилэнх хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	дээд
2	Өлзийсайхан овогтой Хүдрээ	Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн ердийн гишүүн,	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Санхүү эрхэлсэн захирал	дээд
4	Кэйт Беннетт	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
5	Майк Рего	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд

7	Халтар овогтой Батхишиг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Мажигсүрэн овогтой Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Сий Кок Хенг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хай Би Ойл” ХК **2016 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2016 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2016 оны 05 сарын 23-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг, Б.Пүрэвбаатар, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Батхишигийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Пүрэвбаатар, Х.Батхишиг, Сий Кок Хенг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Пүрэвбаатарыг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Х.Батхишиг, М.Батсүрэн, Кэйт Беннетт гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Кэйт Беннетт-г томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд гишүүдийн орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 5 удаа хуралдаж 10 тогтоол батлагдаж гарсан.

- Ногдол ашиг хувиарлах эсэх тухай, аудитын тайлан дүгнэлт батлах, цалингийн шинэчилсэн төсөв батлах, ТУЗ-н гишүүдийн болон зөвлөхийн цалин олгохгүй тухай компанийн санхүү эдийн засагтай холбоотой 4 асуудал.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, ТУЗ-ын дарга, ТУЗ-ын нарийн бичиг, Гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох, гишүүнээс чөлөөлөх тухай компанийн

удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 6 асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.

“Хай Би Ойл” ХК **2015 оны 04 сарын 30**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

“Хай Би Ойл” ХК **2014 оны 04 сарын 22**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах